

ИНФЛЯЦИЙН ХҮЛЭЭЛТ

ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ТАЙЛАН



2019 ОНЫ I УЛИРЛЫН ТАЙЛАН

Энэхүү тайланд зөвхөн түүвэр судалгаанд хамрагдсан иргэд, аж ахуй нэгж болон шинжээчдийн эдийн засгийн төлөв байдлын талаарх хүлээлтийн үр дүнг нээгдсэн тайлагнасан учир Монголбанкны албан ёсны байр суурь биш болно.



ИРГЭДИЙН ИНФЛЯЦИЙН ХҮЛЭЭЛТ

1-Р БҮЛЭГ



ТҮҮВЭР СУДАЛГАА
2019 ОНЫ I УЛИРАЛ

1. Иргэдийн Инфляцийн Хүлээлт


Инфляцийн талаарх иргэдийн хүлээлтийн түүвэр судалгааг Дэлхийн банкны “САРГ” системд суурилан 2019 оны 02 дугаар сарын 18-наас 22-ны өдрүүдэд Улаанбаатар хотын 7 дүүргийн нийт 720 иргэнийг санамсаргүй түүврийн аргаар сонгон судалгааг гүйцэтгэлээ. Түүвэр судалгаанаас дараах гол үр дүнгүүд гарлаа:

- Иргэд инфляцийн түвшинг i) чанарын хариултын хувьд 2019 оны II улиралд 3.7%, **2020 оны I улиралд 6.5%** байхаар; ii) тоон хариултын хувьд 2019 оны II улиралд 6.0%, **2020 оны I улиралд 6.4%** байхаар; iii) мэдрэмж (үнийн өсөлтийг мэдэрч буй байдал)-д суурилсан инфляцийн хүлээлтийн хувьд 2019 оны II улиралд 9.9%, **2020 оны I улиралд 10.3%** байхаар тус тус хүлээж байна;
- Судалгаанд хамрагдсан иргэдийн 67.5% нь 2020 оны эхэнд инфляцийн түвшинг зорилтот түвшин болох 8%-аас хэтрэхгүй гэж хүлээж байна;
- Иргэд хадгаламж, зээлийн хүү ирэх нэг жилийн хугацаанд өснө гэсэн хүлээлттэй байна;
- Иргэдийн дунд төгрөгт итгэх итгэл өндөр хэвээр байж, эдийн засгийн төлөв байдал сайжирна гэсэн эерэг хүлээлт давамгайлж байна.


1.1. Инфляцийн хүлээлт

Чиглэлийн индексээс харахад иргэдийн инфляцийн талаарх хүлээлт хандлагаараа 2018 оны 3-р улирлаас эхлэн өсөх төлөв ажиглагдаж байсан бол 2019 оны 1-р улирлын судалгааны дүнгээр иргэдийн дунд инфляци буурна гэсэн хандлага мэдэгдэхүйц нэмэгдлээ /*Зураг 1-1*/.

Зураг 1- 1. Үнийн өсөлтийн талаарх хандлага /чиглэлийн индекс, ирэх 12 сар/



Зураг 1- 2. Иргэдийн инфляцийн хүлээлт /чанарын болон тоон хариултаар/



Эх сурвалж: Монголбанк, иргэдийн хүлээлтийн түүвэр судалгаа

Иргэдийн инфляцийн хүлээлтийг тоон болон чанарын аргачлалаар тооцлоо. Чанарын хариултыг Карлсон-Паркины аргачлалд тулгуурлан тоон үзүүлэлт рүү шилжүүлж тооцоход иргэд инфляцийг 2019 оны II улиралд 3.7%, **2020 оны I улиралд 6.5%** байхаар хүлээж байна. Харин иргэдийн инфляцийн хүлээлтийг тоон хариултад тулгуурлан тооцоход 2019 оны II улиралд 6.0%, **2020 оны I улиралд 6.4%**-тай байна. Түүнчлэн өнгөрсөн үеийн мэдрэмжид суурилсан инфляцийн түвшин */perceived inflation²* 2019 оны II улиралд 9.9%, **2020 оны I улиралд 10.3%**-тай байхаар тус тус хүлээгдэж байна */Зураг 1-2/*.


Хүлээлтийн чанарын хариултаас харвал иргэдийн 67% нь ирэх 12 сард үнийн түвшин ерөнхийдөө өснө гэж үзсэн бөгөөд үүнээс 23% нь үнийн түвшин илүү хурдацтайгаар өснө (*өмнөх судалгааны дүнгүүдээс буурсан*), 44% нь үнэ өснө гэхдээ өсөлтийн хурдац өөрчлөгдөхгүй гэж хариулжээ */Зураг 1-3/*.

Иргэдийн инфляцийн хүлээлтийг тоон утгаар асууж, хариултуудын жигнэсэн дундаж утгыг тооцон үзэхэд инфляцийг ирэх улиралд буюу 2019 оны II улиралд 6.0%, жилийн дараа буюу 2020 оны I улиралд 6.4%-тай байхаар хүлээж байна. Өөрөөр хэлбэл тоон хариултын хувьд **иргэдийн дунд ирэх 12 сарын хугацаанд инфляци өнөөдрийн түвшнээс буурна гэсэн хүлээлт давамгайлж байна** */Зураг 1-4/*.


Харин жилийн дараа инфляци 8-10% байна гэсэн хариултыг иргэд хамгийн их давтамжтай өглөө.

²-Монголбанкны Судалгааны Товхимол-7. “Инфляцийн хүлээлтийг тооцох арга, аргачлалыг өргөжүүлэх нь” сэдэвт судалгааны ажлаас дэлгэрэнгүйг харна уу.

Зураг 1- 3. Ирэх 12 сарын хугацаанд үнийн түвшин хэрхэн өөрчлөгдөх вэ?



Зураг 1- 4. Иргэдийн инфляцийн хүлээлтийн тархалт /тоон хариултаар/




Эх сурвалж : Монголбанк, иргэдийн хүлээлтийн түүвэр судалгаа


Хүлээлтийн тоон хариултаас харахад иргэд жилийн дараах хүнсний бус бүтээгдэхүүний инфляцийг 6.1%, хүнсний бүтээгдэхүүний инфляцийг 6.4%-тай байхаар хүлээж байна /*Зураг 1-5*/. Инфляцийн хүлээлтийн талаарх хариултын тархалтаас харахад 2020 оны эхний улиралд хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт 8-10% байх хариулт хамгийн өндөр давтамжтай байна.

2018 оны IV улиралд судалгаанд хамрагдсан иргэдийн 75% нь ирэх нэг жилийн хугацаанд инфляцийн түвшинг зорилтот түвшин болох 8%-аас хэтрэхгүй гэж хүлээж байсан нь энэ удаагийн түүвэр судалгаагаар 67.5% болж буурсан байна. Энэ нь иргэдийн дунд ирэх нэг жилийн хугацаанд инфляцийн түвшинг зорилтот түвшнээс давна гэсэн хүлээлт нэмэгдэж байгааг илэрхийлж байна /*Зураг 1-6*/.

Зураг 1- 5. Инфляцийн хүлээлтийн тархалт /хүнсний, хүнсний бус, ирэх 12 сар/



Зураг 1- 6. Инфляцийн хүлээлтийн хуримтлагдсан тархалт /тоон хариултаар/



Эх сурвалж : Монголбанк,иргэдийн хүлээлтийн түүвэр судалгаа

1.2. Эдийн засгийн өсөлт, иргэдийн орлого

2017 оны I улирлаас хойш иргэд ирэх нэг жилийн хугацаанд эдийн засгийн ерөнхий байдал сайжирна гэсэн эерэг хүлээлттэй байсан хэдий ч өмнөх улирлын түүвэр судалгааны дүнгээр эдийн засгийн чиглэлийн индекс “эдийн засгийн байдал муудна” гэсэн мужид гарсан билээ. Харин энэ удаагийн түүвэр судалгаагаар тус индекс “эдийн засгийн байдал сайжирна” гэсэн мужид эргээд шилжсэн байна. Өөрөөр хэлбэл, судалгаанд хамрагдсан иргэдийн дийлэнх нь ирэх 12 сарын хугацаанд эдийн засгийн ерөнхий байдал сайжирна гэсэн хүлээлттэй байна /Зураг 1-7/.

Энэ удаагийн иргэдийн өрхийн санхүүгийн байдлын чиглэлийн индексээс харахад иргэдийн дийлэнх нь ирэх 12 сарын хугацаанд өрхийн санхүүгийн байдал сайжирна гэсэн эерэг хүлээлттэй байгаа бөгөөд өмнөх улиралтай харьцуулахад огцом өслөө /Зураг 1-8/.

1.3. Валютын ханшийн хүлээлт

Валютын ханшийн хүлээлтийн чиглэлийн индексээс харахад 2017 оны I улирлаас эхлэн иргэдийн хувьд төгрөгийн ханш чангарна гэсэн хүлээлт нэмэгдсэн, улмаар 2019 оны I улиралд явуулсан судалгаагаар иргэдийн дунд төгрөгийн ханш чангарна гэсэн хүлээлт өндөр хэвээр хадгалагдлаа /Зураг 1-9/.

Зураг 1-7. Ирэх 12 сарын эдийн засгийн төлөвийн талаарх хүлээлт /ирэх 12 сард/



Зураг 1-8. Өрхийн санхүүгийн талаарх хүлээлт /ирэх 12 сард/



Тайлбар: Чиглэлийн индекс [-1;1] завсарт утгаа авна. [0;1] эдийн засгийн байдал сайжирна, [0] хэвэндээ байна, [0;-1] муудна.

Зураг 1-9. Ирэх 12 сарын хугацаанд валютын ханшийн талаарх хүлээлт




Эх сурвалж: Монголбанк, иргэдийн инфляцийн хүлээлтийн түүвэр судалгаа

1.4. Хадгаламж, зээлийн хүүний хандлага

2017 оны I улирлаас эхлэн иргэдийн дунд зээлийн хүү буурна гэсэн хүлээлт нэмэгдсэн. Харин 2019 оны I улиралд явуулсан судалгаагаар иргэдийн дийлэнх нь ирэх 12 сарын хугацаанд зээлийн хүү өснө гэсэн хүлээлттэй байна /Зураг 1-10/.

Судалгаанд хамрагдсан иргэдийн дунд ирэх 12 сарын хугацаанд хадгаламжийн хүү нэмэгдэнэ гэсэн хүлээлт давамгайлж байна /Зураг 1-11/.

Зураг 1- 10. Зээлийн хүүний талаарх хүлээлт /ирэх 12 сард/



Зураг 1-11. Хадгаламжийн хүүний талаарх хүлээлт /ирэх 12 сард/



Эх сурвалж : Монголбанк,иргэдийн хүлээлтийн түүвэр судалгаа

АЖ АХУЙ НЭГЖИЙН ИНФЛЯЦИЙН ХҮЛЭЭЛТ

2-Р БҮЛЭГ



ТҮҮВЭР СУДАЛГАА
2019 ОНЫ I УЛИРАЛ

2. Аж Ахуй Нэгжийн Инфляцийн Хүлээлт

ААН-ийн хүлээлтийн түүвэр судалгааг Дэлхийн банкны “САРГ” системд суурилан 2019 оны 2 дугаар сарын 22-ны өдрөөс 27-ны өдрүүдэд Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй нийт 359 бизнес эрхлэгчдийг санамсаргүй түүврийн аргачлалаар сонгон авч гүйцэтгэлээ. Түүвэр судалгаанаас дараах үр дүнгүүд гарлаа:

- ААН-үүд инфляцийн түвшинг i) чанарын хариултын хувьд 2019 оны II улиралд 2.7%, **2020 оны эхэнд 3.3%**; ii) тоон хариултын хувьд 2019 оны II улиралд 6.0%, **2020 оны эхэнд 6.5%**; iii) мэдрэмж (үнийн өсөлтийг мэдэрч буй байдал)-д суурилсан инфляцийн хүлээлтийн хувьд 2019 оны II улиралд 5.5%, **2020 оны эхэнд 6.1%** байхаар тус тус хүлээж байна;
- ААН-үүдийн дунд төгрөгийн ханш тогтвортой байна гэсэн хүлээлт давамгайлж байна;
- ААН-үүд ирэх 3 сарын хугацаанд нийт эрэлт өсөж, борлуулалтын орлого нэмэгдэнэ гэж хүлээж байна;
- ААН-үүд цалингийн түвшинд өөрчлөлт оруулахгүй гэж төлөвлөж байна.


2.1. Инфляцийн хүлээлт

Чиглэлийн индексээс харахад ААН-үүдийн инфляцийн талаарх хүлээлт 2018 оны III болон IV улиралд өсөх чиглэлтэй байсан нь энэ удаагийн түүвэр судалгаагаар буурах чиглэлтэй гарлаа. Гэсэн хэдий ч, тус индекс нь инфляцийн түвшин хэвэндээ байна гэсэн мужид хэвээр хадгалагдаж байна. Өөрөөр хэлбэл, 2019 оны I улирлын судалгааны дүнгээр ААН-үүдийн дийлэнх нь инфляцийг одоогийн түвшинд хадгалагдана гэж үзлээ /*Зураг 2.1*/.

Зураг 2-1. ААН-ийн үнийн өсөлтийн хүлээлт /чиглэлийн индекс, 12 сарын дараа/



Зураг 2-2. ААН-ийн инфляцийн хүлээлт /чанар болон тоон хариултаар/



Эх сурвалж: Монголбанк, ААН-ийн хүлээлтийн түүвэр судалгаа

¹-Өснө, буурна гэсэн хариултуудын зөрүүгээр чиглэлийн индексийг (тэнцлийн статистик) тооцно. Ингэхдээ ААН-үүдээс ирэх 12 сард үнийн өсөлт ямар байх талаар асууж, хариултуудыг [3;-1] байхаар нормчилж чиглэлийн индексийг тооцсон.

ААН-үүдийн хүлээлтийг тоон болон чанарын аргачлалаар тооцлоо. Чанарын хариултыг Карлсон-Паркины аргачлалд тулгуурлан тоон үзүүлэлт рүү шилжүүлж тооцоход бизнес эрхлэгчид инфляцийг 2019 оны II улиралд 2.7%, 2020 оны I улиралд 3.3%-тай байхаар хүлээж байна.

Бизнес эрхлэгчдийн инфляцийн хүлээлтийг тоон утгаар асууж, хариултуудын жигнэсэн дундаж утгыг тооцон үзэхэд инфляцийг ирэх улиралд 6%, жилийн дараа буюу 2020 оны I улиралд 6.5%-тай байхаар хүлээж байна. Ирэх оны инфляцийг 4-6 хувьд байна гэсэн хариултыг судалгаанд хамрагдсан ААН-үүдийн дийлэнх нь өглөө /Зураг 2.3/.

Түүнчлэн өнгөрсөн үеийн мэдрэмжид суурилсан инфляцийн түвшин /perceived inflation² 2019 оны эхний хагас жилд 5.5%, 2020 оны эхээр 6.1%-тай байхаар тус тус хүлээж байна /Зураг 2.2/.


Судалгаанд хамрагдсан ААН-үүдийн 73% нь 2019 оны II улиралд инфляцийн түвшинг зорилтот түвшин болох 8%-аас бага байна гэж үзсэн бол ирэх оны I улиралд ААН-үүдийн 65% нь инфляци зорилтот түвшнээс доогуур түвшинд байна гэж хүлээж байна /Зураг 2.4/.

2.2. Валютын ханш, зээлийн хүүний хүлээлт


2018 оны IV улирлын түүвэр судалгаагаар ханшийн чиглэлийн индекс нь төгрөгийн ханш суларна гэсэн мужид шилжсэн байсан нь энэ удаагийн түүвэр судалгаагаар төгрөгийн ханш чангарна гэсэн мужид дахин шилжлээ. Өөрөөр хэлбэл, ААН-үүд төгрөгийн ханшийг өнөөгийн түвшнээс бага зэрэг чангарах буюу харьцангуй тогтвортой байна гэж хүлээж байна /Зураг 2.5/.

²-Монголбанкны Судалгааны Товхимол-7. “Инфляцийн хүлээлтийг тооцох арга, аргачлалыг өргөжүүлэх нь” сэдэвт судалгааны ажлаас дэлгэрэнгүйг харна уу.

Зураг 2-3. ААН-ийн инфляцийн хүлээлт /тархалт, тоон хариултаар/



Зураг 2-4. ААН-ийн инфляцийн хүлээлт /хуримтлагдсан тархалт, тоон хариултаар/



Зураг 2-5. Ирэх 12 сарын хугацаан дахь валютын ханшийн хүлээлт



Эх сурвалж: Монголбанк, ААН-ийн хүлээлтийн түүвэр судалгаа

2019 оны II улиралд зээлийн хүүний чиглэлийн индекс өмнөх улирлаас бага зэрэг буурсан дүнтэй гарсан боловч өсөх мужид хадгалагдаж байна. Энэ нь ААН-үүдийн дунд зээлийн хүү ирэх 12 сарын хугацаанд өснө гэсэн хүлээлттэй байгааг илтгэнэ /*Зураг 2.6*/.

2.3. Аж ахуй нэгжийн үйл ажиллагаа

ААН-үүд өнгөрсөн 3 сарын хугацаанд бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт харьцангуй өссөн гэж үзэж байгаа бөгөөд ирэх 3 сарын хугацаанд борлуулж буй барааны эрэлт мөн өснө гэсэн хүлээлттэй байна /*Зураг 2.7*/.

ААН-үүдийн хувьд үйл ажиллагаагаа тэлэх орон зай нэмэгдэж, улмаар ирэх 3 сарын хугацаанд ажлын байрыг бага зэрэг нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй байна. Харин цалинд ирэх 3 сарын хугацаанд өөрчлөлт оруулахгүй гэж төлөвлөж байна /*Зураг 2.8*/.

Судалгаанд оролцогч бизнес эрхлэгчдийн 23% нь ирэх 3 сарын хугацаанд үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр төлөвлөж байгаа нь өмнөх улирлын судалгааны үр дүнгээс 6%-иар өссөн байна. Үйл ажиллагаагаа өргөжүүлэх ААН-үүдийн дийлэнх нь санхүүжилтээ өөрийн хөрөнгөөр (45%) болон банкны зээлээр (24%) бүрдүүлнэ гэж хариулжээ /*Хавсралт 2-3*/.

Тайлбар: Индекс [-1;1] завсарт утгаа авна.]0;1] өснө, [0] өөрчлөгдөхгүй,]0;-1] буурна.

Зураг 2-6. Ирэх 12 сарын хугацаанд зээлийн хүүний хүлээлт



Зураг 2-7. Бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт /өнгөрсөн 3 сар болон ирэх 3 сард/



Зураг 2-8. Ирэх 3 сарын хугацаанд ажлын байр болон цалингаа нэмэгдүүлэх эсэх



Эх сурвалж: Монголбанк, ААН-ийн хүлээлтийн түүвэр судалгаа

ДҮГНЭЛТ, ХАВСРАЛТ

3-Р БҮЛЭГ



ТҮҮВЭР СУДАЛГАА
2019 ОНЫ I УЛИРАЛ

3. ДҮГНЭЛТ

3.1. Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгааны дүгнэлт

Судалгааны үр дүнгээс харахад иргэд 2020 оны I улиралд инфляцийг 6.4% /тоон хариултын хувьд/, 10.3% /мэдрэмжид суурилсан/, 6.5% /чанарын хариултын хувьд/ тус тус байхаар хүлээж байна.

Судалгаанд хамрагдсан иргэдийн 67.5% нь 2020 оны эхний улиралд инфляцийн түвшинг зорилтот түвшин болох 8%-аас хэтрэхгүй гэж хүлээж байна

2018 оны IV улиралд иргэд ирэх нэг жилийн хугацаанд эдийн засгийн ерөнхий байдал муудна гэсэн сөрөг хүлээлттэй байсан бол энэ удаагийн түүвэр судалгааны дүнгээр иргэдийн дийлэнх нь ирэх 12 сарын хугацаанд эдийн засгийн байдал сайжирна гэсэн хүлээлттэй гарлаа.

Ирэх нэг жилийн хугацаанд хадгаламж болон зээлийн хүү өснө гэсэн хүлээлт давамгайлж байна.

3.2. Аж ахуй нэгжийн инфляцийн хүлээлтийн түүвэр судалгааны дүгнэлт

ААН-үүдийн инфляцийн хүлээлтийн санал асуулгын дүнгээр ААН-үүд 2020 оны эхэнд инфляцийг 3.3% /чанарын хариулт/, 6.1% /мэдрэмжид суурилсан/, 6.5% /тоон хариулт/ тус тус байхаар хүлээж байна.

ААН-үүдийн 65% нь 2020 оны I улиралд инфляцийн түвшинг зорилтот түвшин болох 8%-аас доогуур байна гэж хүлээж байна.


Мөн судалгаанд хамрагдсан ААН-үүдийн дийлэнх нь ирэх 12 сарын хугацаанд төгрөгийн ам.доллартай харьцах ханшийг тогтвортой байна гэж хүлээж байна.

Ирэх 3 сарын хугацаанд нийт эрэлт нэмэгдэж, борлуулалтын орлого өссөнөөр үйл ажиллагаагаа тэлэх орон зай сайжирна гэж судалгаанд хамрагдсан ААН-үүд харж байна. Мөн эдгээр ААН-үүд цалингийн түвшинд өөрчлөлт оруулахгүй боловч ажлын байрыг бага зэрэг нэмэгдүүлэхээр төлөвлөж байна.


ХАВСРАЛТ 1.

Судалгаанд оролцсон нийт иргэдийн 58% нь эмэгтэй, 42% эрэгтэй бөгөөд насны байдлаар нь авч үзвэл 40% нь 18-25, 29% нь 26-35, 18% нь 36-45, 7% нь 46-55, 6% нь 56-аас дээш гэсэн насны ангилалд хамрагдаж байна. /Хавсралт 1-1, Хавсралт 1-2/

Хавсралт 1-1. Хүйс



Хавсралт 1-2. Нас



Мөн судалгаанд оролцогчидийн 47% нь бүрэн дунд, 48% нь дээд боловсролтой бөгөөд тэн хагас нь сард 700.000 төгрөгөөс их зардал гаргадаг байна.

Хавсралт 1-3. Боловсролын түвшин




Хавсралт 1-4. Сарын дундаж зардал



Эх сурвалж : Монголбанк,иргэдийн хүлээлтийн түүвэр судалгаа

Инфляцийн талаарх иргэдийн хүлээлтийн түүвэр судалгааг Дэлхийн банкны “САРГ” системд суурилан 2019 оны 2 дугаар сарын 18-наас 22-ны өдрүүдэд Монгол Улсын Их Сургууль болон Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийн оюутнуудтай хамтран Улаанбаатар хотын 7 дүүргийн 720 иргэнийг санамсаргүй түүврийн аргаар сонгон судалгааг гүйцэтгэлээ. Түүвэр судалгаа авсан газарзүйн тархалтыг *Хавсралт 1-5*-т үзүүлэв.

Хавсралт 1-5. Түүвэр судалгаа авсан газарзүйн тархалт



ХАВСРАЛТ 2.

Судалгаанд хамрагдсан нийт 359 аж ахуй нэгж, байгууллагуудыг өмчлөлийн хэлбэрээр авч үзвэл 174 (48%) нь хязгаарлагдмал хариуцлагатай компани, 143 (40%) нь бусад хэлбэрийн, 20 (6%) нь хувьцаат компани, 19 (5%) нь нөхөрлөл болон үлдсэн 3 (1%) нь өөр бусад төрлийн өмчлөлийн хэлбэртэй байгууллагууд байлаа (*Хавсралт 2-1*).

Хавсралт 2-1. Аж ахуй нэгжийн тоо /өмчлөлөөр/

Аж ахуйн нэгжийн хэлбэр	Тоо	Хувь
Хязгаарлагдмал хариуцлагатай компани	174	48%
Нөхөрлөл	19	5%
Хоршоо	1	0%
Хувьцаат компани	20	6%
Төрийн өмчит үйлдвэрийн газар	2	1%
Бусад	143	40%
НИЙТ ДҮН	359	100,0%

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн салбаруудаар ангилан авч үзвэл нийт 359 ААН-ээс үйлчилгээ эрхэлдэг 51%, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхэлдэг 31%, боловсруулах үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлдэг 4% болон бусад төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг 14% байна (*Хавсралт 2-2*).

Хавсралт 2-2. Аж ахуй нэгжийн тоо /салбараар, ажилтны тоогоор/

Салбарын ангилал	Ажилчдын тоо /бүлгээр/					Бүгд
	< 10	11–19	20–49	50–100	101 <	
Хөдөө аж ахуй	0%	0%	0%	0%	0%	0%
Уул уурхай, олборлох	0%	0%	0%	0%	0%	1%
Боловсруулах үйлдвэр	3%	0%	1%	0%	0%	4%
Барилга	2%	0%	0%	0%	0%	3%
Б/Ж худалдаа	25%	2%	3%	0%	0%	31%
Үйлчилгээ	40%	3%	4%	2%	2%	51%
Тээвэр	1%	0%	0%	0%	0%	1%
Бусад	7%	0%	0%	1%	0%	9%
НИЙТ ДҮН	76,9%	6,3%	9,7%	3,7%	3,5%	100%

Эх сурвалж: Монголбанк, ААН-ийн хүлээлтийн түүвэр судалгаа

Судалгаанд хамрагдсан нийт 359 аж ахуй нэгж, байгууллагуудын дийлэнх буюу 76.9% нь 9 хүртэл ажилчинтай, 6.3% нь 10-19 ажилчинтай, 9.7% нь 20-49 ажилчинтай, үлдсэн 7.2% нь 50-с дээш ажилчинтай аж ахуй нэгжүүд хамрагджээ (*Хавсралт 2-2*).

Судалгаанд оролцогч ААН-үүдийн дийлэнх буюу 77% нь ирэх 3 сарын хугацаанд компанийнхаа үйл ажиллагааг өргөжүүлэх төлөвлөгөөгүй байна гэж хариулжээ. Харин бизнес эрхлэгчдийн 23% нь ирэх 3 сарын хугацаанд үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд үүний тулд ихэнх ААН өөрийн хөрөнгөөр (45%) болон банкны зээлээр (24%) санхүүжүүлнэ гэж хариулсан байна /*Хавсралт 2-3*/.

Хавсралт 2-3. Ирэх 6 сарын хугацаанд үйл ажиллагааг өргөжүүлэх эсэх

Санхүүжилтийн хэлбэр	Үйл ажиллагаагаа өргөжүүлэх үү?	
	Тийм	Үгүй
Банкны зээлээр	24%	
Компанийн өөрийн хөрөнгөөр	45%	
Хувьцаа гаргах	3%	
Гадаад эх үүсвэрээр	5%	
Бусад санхүүгийн байгууллагын эх үүсвэрээр	5%	
Тэтгэлэг, тусламжаар	2%	
Хувь хүнээс зээлэх	6%	
Бусад	9%	
НИЙТ ДҮН	23%	77%

Эх сурвалж: Монголбанк, ААН-ийн хүлээлтийн түүвэр судалгаа

Хавсралт 2-4. Түүвэр судалгаа авсан газарзүйн тархалт

